

Төрийн албаны зөвлөлийн  
2020 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн  
309 дүгээр тогтоолын 27 дугаар хавсралт

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан  
шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон  
Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг  
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Биеийн тамир, спортын улсын хороо

Албан тушаалын нэр:

Үндэсний болон баг, өвлийн  
спортын бодлогын хэрэгжилт  
хариуцсан мэргэжилтэн

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтэс

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-6

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,  
Бага тойруу-55, Спортын төв ордон

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Биеийн тамир, спортын салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг боловсронгуй болгох чиглэлээр санал, дүгнэлт боловсруулах, үндэсний спорт, багийн болон өвлийн спортын төрлүүдийн хөгжлийг хангах, үйл ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Үндэсний спортын өв соёл, хэв маягийг хадгалж хөгжүүлэх, хөгжлийн бодлогын хэрэгжилт, мэргэжлийн удирдлага, арга зүйн зөвлөмжөөр хангах, оролцоог нэмэгдүүлэх;
- 2.Багийн спортын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах, шинжилгээ дүгнэлт гаргах, зөвлөмж хүргэх, тайлагнах;
- 3.Өвлийн спортын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах, шинжилгээ дүгнэлт гаргах, зөвлөмж хүргэх, тайлагнах;
- 4.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.Үндэсний спортын хөгжлийг хүн ам, газар зүйн байршилтай холбогдуулан үндэсний өв соёлыг дэлгэрүүлэх, өвлүүлэн уламжлуулах, спортын салбарын бодлогын хэрэгжилтийг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах;</p> <p>2.Үндэсний спортын хөгжлийн талаар судалгаа хийх, орчин үеийн зорилтод нийцсэн үйл ажиллагааны менежмент, аргачлалыг нэвтрүүлэх, үр дүнг тооцон хяналт тавин ажиллах;</p> <p>3.Өмчийн олон хэлбэрийн байгууллагуудтай хамтран үндэсний спортын өв соёлыг түгээх хадгалдах бүх нийтэд мэдлэг, мэдээлэл ил тод олгоход чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах, хэрэгжилтийг хангах.</p>	<p>Үндэсний өв соёл, хэв маягийг хадгалуулах үйл ажиллагаа шинэ шатанд гарсан байна.</p>	Г
2 дугаар зорилтын хүрээнд	<p>1.Багийн спортын хөгжлийг хүн ам, зорилтот бүлгийн хэв шинжтэй уялдуулан, үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагаа, спортын салбарын бодлогын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах;</p> <p>2.Багийн спортын хөгжлийн талаар судалгаа хийх, орчин үеийн зорилтод нийцсэн үйл ажиллагааны менежмент,</p>	<p>Үндэсний хөтөлбөр, бодлогын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.</p> <p>Судалгаа хийж, аргачлал нэвтрүүлсэн байна.</p>	<p>Г</p> <p>Г,Т</p>



	аргачлалыг нэвтрүүлэх, үр дүнг тооцон хяналт тавин ажиллах;		
	3.Өмчийн олон хэлбэрийн байгууллагуудтай хамтран багийн спортыг сурталчлах үйл ажиллагаа зохион байгуулах, хэрэгжилтийг хангах.	Олон нийтийг мэдээллээр хангаж ажилласан байна.	Г,Т
3 дугаар зорилтын хүрээнд	1.Өвлийн спортын хөгжлийг хүн ам, газар зүйн байршил, зорилтот бүлгийн хэв шинжтэй уялдуулан, үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагаа, спортын салбарын бодлогын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах;	Бодлогын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Г
	2.Өвлийн спортын хөгжлийн талаар дүгнэлт, судалгаа, нэгтгэл хийх, орчин үеийн зорилтод нийцсэн үйл ажиллагааны менежмент, аргачлалыг нэвтрүүлэх, үр дүнг тооцон хяналт тавин ажиллах;	Хөгжих таатай орчин нөхцөл бүрдэнэ.	Г,Х
	3.Өмчийн олон хэлбэрийн байгууллагуудтай хамтран өвлийн спортыг дэлгэрүүлэх бүх нийтэд мэдлэг, мэдээлэл олгоход чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах, хэрэгжилтийг хангах; тайлagnaх.	Хамтран ажилласан байна.	Г,Т
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлagnaх, дүгнүүлэх ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх;	Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.	Х,Г
	2.Удирдлага бусад нэгжээс шаардсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл судалгааг шуурхай, чанартай, хугацаанд нь гаргаж өгөх;	Мэдээ, мэдээллийг бодит, үнэн зөв гаргасан байна	Г
	3.Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлж эрхлэх асуудлын чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, тайлан, холбогдох материалыг "Байгууллагын хөтлөх хэргийн	Архив албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцсэн байна.	Г



	жагсаалт"-ын дагуу архивын нэгж болгон хадгалуулах;		
	4. Эрхлэх асуудлын хүрээнд мэдээлэлийн сангийн тоон үзүүлэлт, асуумж өгөгдлийг бүрдүүлэх, хяналт тавих, нэгтгэх, тайлагнах.	Мэдээллийн сангийн үйл ажиллагаа тогтмолжино.	Г,Т

### III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	-спорт /1014/; -багш, биеийн тамирын боловсрол /011410/; -спортын менежмент.		
Мэргэшил	Төрийн албаны богино, дунд хугацааны сургалтад хамрагдсан байх.		
Туршлага	Төрийн албандаа эсхүл мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан байх.		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>- мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах, мэдээлэл дэх дутуу алдаатай, нийцтэй бус мэдээллийг илрүүлэх;</li> <li>- нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах;</li> <li>- байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх;</li> <li>- судалгааны арга зүйн мэдлэгтэй байх;</li> <li>- шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг дүгнэх.</li> </ul>	
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>- үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх;</li> <li>- төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж, харилцааны соёлыг эрхэмлэх;</li> <li>- өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх;</li> <li>- бүтээлч, санаачилгатай ажиллах, үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх;</li> <li>- үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;</li> <li>- ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх;</li> <li>- бусад.</li> </ul>	
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> <li>- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа эерэг мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах;</li> <li>- бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц, ажил хэрэгч нээлттэй харилцааг бий болгох;</li> <li>- багийн зорилго, үйл ажиллагааг ойлгох, хүрээлэлд дасан зохицох, үр бүтээмжтэй ажиллах;</li> <li>- мэдлэг туршлага ур чадвараа бусадтай хуваалцах;</li> <li>- хамт олны эерэг, нээлттэй уур амьсгалыг дэмждэг байх;</li> <li>- бусад.</li> </ul>	



		<ul style="list-style-type: none"> <li>- харилцааны соёлыг эрхэмлэх;</li> <li>- албан ажлын чиг үүргийн дагуу зөвлөгөө мэдээллээр ханган ажиллах чадвартай байх;</li> <li>- компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэй технологи, ашиглах чадвартай байх;</li> <li>- төрийн албан хэрэг хөтлөлт, албан бичгийн боловсруулалт, монгол хэл, найруулгын чадвартай байх;</li> <li>- англи хэл эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх;</li> <li>- бие даан хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, шуурхай засах, дүгнэлт хийх чадвартай байх;</li> <li>- худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байх;</li> <li>- хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх;</li> <li>- албан ажлын хүрээнд олж авсан мэдээллийг нууцлах;</li> <li>- харилцааны оновчтой арга хэлбэрийг ашиглаж, асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг шуурхай хүргэх;</li> <li>- монгол бичгээр уншиж, бичих чадвартай байх.</li> </ul>
	Bусад	


#### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга.

<u>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект:</u>
	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн газар, хэлтэс;</li> <li>- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрүүдийн ажилтан;</li> <li>- Иргэн хуулийн этгээд.</li> </ul>

#### V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
<u>Албан тушаал:</u> <b>ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА</b>  (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 20.09.09 дугаар сарын 28-ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> <b>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ ШИЙДВЭРИЙН ОГНОО: 20.09.09</b> <u>Дугаар:</u> 309 

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:**

**Байгууллагын нэр:**

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО**

**Шийдвэрийн огноо:** 2020. 9. 28.

**Дугаар:** 5/08

(тамга/тэмдэг)



Ц. ШАРАВЖАМЦ

